



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 09 дүгээр сар

Гадаад худалдааны эргэлт: \$8,068.1 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 8,068.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.8%-иар буюу 144.8 сая ам.доллараар өссөн. Үүнд экспорт 924.0 сая ам.доллараар өссөн ч импорт 779.2 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.4% буюу 4,956.7 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 15.3% буюу 1,232.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 22.7%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 2.9%-иар тус тус өсчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$24.4 сая

Мөнгөн дүн 2014 оны эхний 9 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл -24.4 сая ам.долларт хүрч, тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 98.6%-иар буюу 1,703.2 сая ам.доллараар буурчээ. Энэ нь экспорт 29.8%-иар өссөн, импорт 16.1%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$213.7 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 213.7 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 1,581.7 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 28.0%-иар өссөн, импорт 16.0%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.585 (Туршилт тооцоо)

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.585-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.5%-иар өслөө.


Экспортын үнийн индекс 10.7%-иар буурсан боловч импортын үнийн индекс түүнээс өндөр хувиар буюу 17.7%-иар буурсан нь гадаад худалдааны нөхцөлийн индекс ийнхүү өсөхөд нөлөөлжээ.

Импортын үнийн индекс өнгөрсөн оны мөн үеэс буурахад удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, барилгын материал, нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 9 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,068.1	7,923.3	8,477.4	144.8	1.8%	(554.1)	-6.5%
Экспорт	4,021.8	3,097.8	3,231.6	924.0	29.8%	(133.8)	-4.1%
Импорт	4,046.2	4,825.4	5,245.8	(779.2)	-16.1%	(420.4)	-8.0%
Тэнцэл	(24.4)	(1,727.6)	(2,014.2)	1,703.2	-98.6%	286.6	-14.2%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 87% + 13%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч нийт экспортын 87%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 89%, нийт экспортын 78%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 4.8 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 3.9 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өсөлт: +29.8%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 29.8%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 25.7%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 43%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс болон төмрийн хүдрийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 19%, 34%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 12%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 952.3 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 28.3 сая ам.доллараар буурснаар нийтдээ 924.0 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж 870 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн хүдэр, цайрын экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулуун нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 476 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үнэ, бусад экспортын бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 36.5 болон 90.4 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар унц тутамд 1,208.2-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 9.1%-иар, өмнөх сараас 6.1%-иар тус тус буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2014 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 6,720.0, 78.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 4.1%-иар, төмрийн хүдэр 11.3%-иар, өмнөх жилийн мөн үеэс зэс 7.8%-иар, төмрийн хүдэр 40.6%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал	3,509	87%		2,712	88%		797	↑29%	25.7%
Чулуун нүүрс	13,473	633	16%	11,357	783	25%	(150)	↓-19%	-6%
Зэсийн баяжмал	966	1,684	42%	469	680	22%	1,004	↑148%	37%
Төмрийн хүдэр/баяж.	4,158	314	8%	4,689	478	15%	(164)	↓-34%	-6%
Боловсруулаагүй нефть	5,051	500	12%	3,535	349	11%	151	↑43%	6%
Цайрын хүдэр ба баяж.	80	90	2%	98	89	3%	1	↑1%	0%
Мөнгөжөөгүй алт	5,126	214	5%	5,960	246	8%	(32)	↓-13%	-1%
Жонш, лейцит, нефелинт	228	52	1%	254	64	2%	(12)	↓-19%	0%
Молибдений хүдэр/баяж	3	22	1%	3	23	1%	(1)	↓-4%	0%
2. Ноос, ноолуур	256.6	6%		220.1	7%		37	↑17%	1%
Ямааны угаа ноолуур	3,889	216	5%	3,915	181	6%	35.0	↑19%	16%
Ямааны сам ноолуур	419	41	1%	402	39	1%	1.5	↑4%	1%
3. Бусад	256	6%		166	5%		90	↑54%	3%
Нийт дүн	4,022			3,098			924.0	↑29.8%	

% 2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	901		(104)		797	
Чулуун нүүрс	146	-97%	(296)	197%	(150)	-19%
Зэсийн баяжмал	720	72%	284	28%	1,004	148%
Төмрийн хүдэр ба баяжмал	(54)	33%	(110)	67%	(164)	-34%
Боловсруулаагүй нефть	160	99%	1	1%	151	43%
Цайрын хүдэр ба баяжмал	(16)	-2259%	17	2359%	1	1%
Мөнгөжөөгүй алт	(34)	108%	3	-8%	(32)	-13%
Жонш, лейцит, нефелинт	(7)	53%	(6)	47%	(12)	-19%
Молибдений хүдэр ба баяжмал	(4)	364%	3	-264%	(1)	-4%
2. Ноос, ноолуур	0.4		36.2		36.5	
Ямааны угаасан ноолуур	(12)	-4%	36.2	104%	35.0	19%
Ямааны самнасан ноолуур	16	103%	(0.0)	-3%	1.5	4%
3. Бусад	51	56%	39	44%	90.4	54%
Нийт	952.3		(28.3)		924.0	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 25% + 42% +21%

Эхний 9 сарын байдлаар нийт импортын 25%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 42%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 21%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар өссөн бол хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний хувийн жин 5%-иар буурч, нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хадгалагдсан байна.

Өсөлт: -16.1%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 12%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 3%-ийг тус тус тайлбарлаж байна. Эхний 3 сарын байдлаар нефтийн импорт нийт импортын бууралтын 8%-ийг тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн нефтийн импорт өссөнөөр уг үзүүлэлт 3% болж буурсан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 25%-иар буюу 566 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 14%-иар буюу 137 сая ам.доллараар буурсан нь нийт импортыг 16.1%-иар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 9%-иар буюу 105 сая ам.доллараар буурахад удаан эдэлгээтэй барааны импорт, ялангуяа суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 26%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 20%-д хүрч буурсан /Дүрслэл 7/. Түргэн эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны эхнээс эхлэн тогтмол түвшинд байсан бол 7 сараас эхлэн буурах хандлагатай болсон. Харин удаан эдэлгээтэй хэрэглээний барааны импортын өсөлт 2013 оны 8 сараас эхлэн тогтмол буурч байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 40%-иар буюу 586 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин барилгын материалын импорт өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 35 сая ам.доллараар өсчээ.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 4%-иар буюу 20 сая ам.доллараар өссөн нь ерөнхий ангиллуудын хувьд өсөлттэй гарсан ганц бүлэг болж байна. Энэ нь цахилгаан эрчим хүчний импортын өсөлтөөр голлон тодорхойлогдож байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчний импорт огцом нэмэгдсэн.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 14%-иар буюу 137 сая ам.доллараар буурчээ. Дүрслэл 8-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай байсан хэдий ч 2013 оны төгсгөлөөс эхлэн буцаад буурч байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2014		2013		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2*
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,022	25%	1,126	23%	(105)	-9%	-2%
Түргэн эдэлгээтэй	546	13%	555	12%	(9)	-2%	-1%
Хүнс	380	9%	397	8%	(17)	-4%	-2%
Эм, тариа	56	1%	55	1%	1	2%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	110	3%	103	2%	7	7%	1%
Удаан эдэлгээтэй	475	12%	571	12%	(96)	-17%	-8%
Гутал, хувцас, цүнх	43	1%	38	1%	5	13%	0%
Гэр ахуйн цах хэрэгсэл ба тавилга	98	2%	107	2%	(9)	-8%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	278	7%	373	8%	(96)	-26%	-8%
Бусад удаан эдэлгээтэй бараа	56	1%	53	1%	4	7%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,694	42%	2,260	47%	(566)	-25%	-12%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	878	22%	1,465	30%	(586)	-40%	-26%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	225	6%	502	10%	(277)	-55%	-12%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	654	16%	963	20%	(310)	-32%	-14%
Барилгын материал	636	16%	601	12%	35	6%	2%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	179	4%	195	4%	(15)	-8%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	455	11%	435	9%	20	4%	0%
Хүнсний орц	27	1%	15	0%	12	78%	3%
Химийн бүтээгдэхүүн	71	2%	74	2%	(3)	-5%	-1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	11	0%	19	0%	(7)	-40%	-2%
Цахилгаан эрчим хүч	93	2%	66	1%	27	41%	6%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	0	0%	0	58%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	253	6%	261	5%	(8)	-3%	-2%
Нефтийн бүтээгдэхүүн	864	21%	1,002	21%	(137)	-14%	-3%
Дизель түнш	481	12%	600	12%	(119)	-20%	-12%
АИ-92, АИ-95	247	6%	224	5%	23	10%	2%
А-80 болон бусад	137	3%	178	4%	(41)	-23%	-4%
Бусад	12	0%	3	0%	9	321%	0%
Нийт дүн	4,046		4,825		(779)	-16.1%	

*2 - Ерөнхий бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

